



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 16 (349)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Монгол Улсын Яамны Эрх зүйн байдлын тухай*
- *Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай*
- *Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар  
Улаанбаатар хот  
2004 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2004 оны дөрөвдүгээр сарын 28 №16 (349)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

187.	Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай	301
188.	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай	302
189.	Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	326
190.	Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	327
191.	Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	329
192.	Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд нэмэлт оруулах тухай	329
193.	Хүн амын орлогын албан татварын хуульд нэмэлт оруулах тухай	330
194.	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай	330
195.	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай	330

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

196.	Хуулийн болон Улсын Их Хурлын тогтоолын төслүүд буцаах тухай	Дугаар 13	330
------	--	-----------	-----

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

197.	Сулэймен Демирелийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай	Дугаар 50	331
198.	Мустафа Буминьг "Алтан гадас" одонгоор шагнах тухай	Дугаар 51	331
199.	Халил Акынжыг "Найрамдал" медалиар шагнах тухай	Дугаар 52	331
200.	Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 54	331

### Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

201.	Дүрэм батлах тухай	Дугаар 66	332
------	--------------------	-----------	-----

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН ЯАМНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

#### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын яам /цаашид "яам" гэх /-ны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2. дугаар зүйл. Яамны эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж

2.1. Яамны эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль,<sup>1</sup> Засгийн газрын тухай<sup>2</sup>, Төрийн албаны тухай<sup>3</sup>, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль<sup>4</sup>, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

## 3 дугаар зүйл. Яам, түүний чиг үүрэг

3.1. Яам нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих хүрээ, тодорхой чиг үүргийг дагнан эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мөн.

3.2. Засгийн газрын бүтцэд ерөнхий чиг үүргийн болон чиглэлийн яам ажиллана.

3.3. Яам нь Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайдад эрхлэх асуудлынхаа хүрээнд стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг нь зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөхөд нь мэргэжил, арга зүй, эрх зүй, техник, зохион байгуулалтын үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.4. Ерөнхий чиг үүргийн яам нь Засгийн газрын үйл ажиллагааны нийт салбарын нийтлэг, чиглэлийн яам нь Засгийн газрын үйл ажиллагааны тодорхой салбарын асуудлаар энэ хуулийн 3.3.-т заасан чиг үүргийг тус тус хэрэгжүүлнэ.

3.5. Яамыг гадаад, дотоодод Монгол Улсын сайд, хуульд өөрөөр заагаагүй бол түүний даалгаснаар болон өөрийн эрх хэмжээний асуудлаар Төрийн нарийн бичгийн дарга төлөөлнө.

## 4 дүгээр зүйл. Яамны үйл ажиллагааны зарчим

4.1. Яамны үйл ажиллагааны үндсэн зарчим нь ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх явдал мөн.

4.2. Яам нь төрийн үйлчилгээний хүртээмж, чанар, шуурхай, соёлч байдлыг хангах, мэргэшсэн байх, ил тод нээлттэй байх, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх, яамд нь бие биенийхээ дотоод хэрэгт үл оролцон харилцан хүндэтгэх зарчмыг баримтлан ажиллана.

## 5 дугаар зүйл. Яамыг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах

5.1. Засгийн газрын үйл ажиллагааны ерөнхий чиг үүрэг болон салбарын чиг үүргийг зохистой хуваарилах үндсэн дээр яамыг Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Дөчин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2, 3 дахь

хэсэгт зааснаар Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хуулиар байгуулж, өөрчлөн байгуулж, татан буулгана.

## 6 дугаар зүйл. Яамны тамга, тэмдэг, бэлгэдэл

6.1. Яам тогтоосон журмаар хийсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

6.2. Энэ хуулийн 6.1-д заасан тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэх журмыг Засгийн газар тогтооно.

6.3. Яам эрхэлсэн ажлын онцлог, түүхэн уламжлалыг илэрхийлсэн бэлгэдэлтэй байж болно.

6.4. Яамны бэлгэдлийн загвар, тодорхойлолт, хэрэглэх журмыг Засгийн газар тогтооно.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Яамны эрхлэх асуудал

## 7 дугаар зүйл. Яамны нийтлэг эрхлэх асуудал

7.1. Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараахь нийтлэг ажил эрхэлнэ:

7.1.1. хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;

7.1.2. хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон сайдын шийдвэрийн төсөл боловсруулах;

7.1.3. салбарын хэтийн болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, үндсэн чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг боловсруулах, төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг хангуулах, хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

7.1.4. төсвийн ерөнхийлөн захирагчаас яам, агентлаг, Засгийн газраас байгуулсан бусад байгууллага, холбогдох аймаг, нийслэлийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулах, гэрээний биелэлтийн явц, үр дүнд хяналт тавих, дүгнэх;

<sup>1</sup>Монгол Улсын Үндсэн хууль-Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн

<sup>2</sup>Монгол Улсын Засгийн газрын тухай хууль-Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1993 оны 3 дугаарт нийтлэгдсэн

<sup>3</sup>Төрийн албаны тухай хууль-Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн

<sup>4</sup>Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль-Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн



## 8 дугаар зүйл. Монгол Улсын сайд

7.1.5. хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон сайдын шийдвэрийг сурталчлах, хуулийг хэрэглэж байгаа практикийг судалж нэгтгэн, боловсронгуй болгох санал боловсруулж холбогдох байгууллагад оруулах;

7.1.6. аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгж, Засаг даргын дэргэдэх холбогдох байгууллагын мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

7.1.7. Засгийн газрын агентлаг, Засгийн газраас байгуулсан бусад байгууллагын хоорондын болон эдгээр байгууллага, аймаг, нийслэлийн захиргааны холбогдох байгууллагын харилцан ажиллагааг уялдуулан зохицуулах;

7.1.8. төрийн албан хаагчдын хэрэгцээг тодорхойлох, тэднийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангахтай холбогдсон бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

7.1.9. хүний эрхийг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх арга хэмжээ авах;

7.1.10. Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, тэдгээрт хууль тогтоомжийг нийцүүлж, мөхлөлтийг хангуулах;

7.1.11. салбарын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад шаардагдах тооцоо, судалгаа, мэдээ материалыг бусад яам, агентлаг, Засгийн газраас байгуулсан бусад байгууллага, аж ахуйн нэгжээс гаргуулж авах;

7.1.12. тухайн салбарын ажиллагсдыг урамшуулах, төрийн дээд шагналаар шагнуулах, цол олгуулах саналыг хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас тогтоосон журмын дагуу холбогдох байгуулагад өргөн мэдүүлэх;

7.1.13. хууль тогтоомжид заасан бусад нийтлэг эрхлэх асуудал.

7.2. Яамны эрхлэх тодорхой асуудлыг хуулиар тогтооно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Яамны удирдлага, зохион байгуулалтын бүтэц

8.1. Яамыг Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд /цаашид "сайд" гэх/ тэргүүлнэ.

8.2. Сайд Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн ажлын хэсэг, тэргүүлж буй яамныхаа аппаратад түшиглэж эрхлэх асуудлын хүрээнийхээ чиглэлээр зөвлөгөө, туслалцаа авч яам, агентлаг, Засгийн газраас байгуулсан бусад байгууллагын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангана.

8.3. Сайдын өөрийн ажлын хэсэг /зөвлөх, туслах, хэвлэл мэдээллийн ажилтан/ нь сайдад бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлж, шуурхай ажлыг нь гүйцэтгэнэ.

8.4. Энэ хуулийн 8.3-т заасан ажилтан ажлаа сайдын өмнө хариуцаж, төрийн албан хаагчийн хувьд яамны аппаратад харьяалагдана.

## 9 дүгээр зүйл. Төрийн нарийн бичгийн дарга

9.1. Төрийн нарийн бичгийн даргыг Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу сайдын саналыг үндэслэн Засгийн газар томилж, чөлөөлнө.

9.2. Төрийн нарийн бичгийн даргыг Төрийн албаны тухай хуульд зааснаас өөр үндэслэлээр төрийн албанаас түр чөлөөлөх, чөлөөлөх, халах, захиргааны санаачлагаар албан тушаалаас нь бууруулахыг хориглоно.

9.3. Төрийн нарийн бичгийн дарга яамны аппаратын ажлыг мэргэшлийн үндсэн дээр зохион байгуулж, удирдана.

9.4. Төрийн нарийн бичгийн дарга үйл ажиллагаандаа хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, тэдгээрт нийцсэн сайдын тушаал, үүрэг даалгаврыг удирдлага болгоно.

9.5. Төрийн нарийн бичгийн дарга нь яамны аппаратын ажлын үр дүнг сайдын өмнө хариуцна.

9.6. Төрийн нарийн бичгийн дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.6.1. яамны аппаратын ажлыг өдөр тутмын удирдлагаар хангах, яамны хэмжээнд мөрдөх дүрэм, заавар, журмыг хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, сайдын тушаалд нийцүүлэн баталж, мөрдүүлэх;

9.6.2 хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, сайдын тушаал, Засгийн газрын хуралдаан, Ерөнхий сайд, сайдаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулж, явц, биелэлтэд хяналт тавих;

9.6.3 яамны төсвийн ерөнхий менежерийн хувьд сайдтай үр дүнгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлийг дүгнүүлэх;

9.6.4 сайдаас эрхлэх асуудлынхаа хүрээний агентлаг, бусад этгээдтэй үр дүнгийн гэрээ байгуулахад нь болон салбарын бодлого зохицуулалт, хэрэгжилтийг хянах асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

9.6.5 сайдын даалгаснаар эрхлэх асуудлынх нь хүрээний агентлаг, бусад байгууллагын удирдлагатай харилцах;

9.6.6 бүрэн эрхийнхээ асуудлаар холбогдох байгууллагатай шууд харилцах;

9.6.7 яамны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөнд заасан хүрээнд хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх;

9.6.8 батлагдсан төсөв, орон тооны дээд хязгаартаа багтаан яамны төсвийн хөрөнгийг тогтоосон журмын дагуу захиран зарцуулах;

9.6.9 хууль тогтоомжид заасны дагуу ажилтныг албан тушаалд томилж, чөлөөлөх, албан тушаалаас нь бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, төрийн албанаас түр чөлөөлөх, чөлөөлөх, халах;

9.6.10 ажилтныг ажлын үр дүнгээр нь шагнаж урамшуулах;

9.6.11 ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах;

9.6.12 зохих журмын дагуу яамны нэр дээр банкинд харилцах данс нээх;

9.6.13 хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрээр олгосон болон сайдаас шилжүүлсэн бусад бүрэн эрх.

9.7 Сайдын түр эзгүйд түүний даалгаснаар байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн бичигт хариу өгч, гаргасан шийдвэрийнхээ хууль зүйн үр дагаврыг өөрөө хариуцна.

9.8 Төрийн нарийн бичгийн дарга энэ хуулийн 9.6-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх

асуудлаар хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрт нийцүүлэн яамны хэмжээнд мөрдөх тушаал гаргаж, биелэлтийг хангуулна.

9.9 Төрийн нарийн бичгийн даргын гаргасан тушаал нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, сайдын тушаалыг зөрчсөн нь тогтоогдсон бол түүнийг уг албан тушаалтан өөрөө, хэрэв уг албан тушаалтан хууль тогтоомжид заасан хугацаанд шийдвэрлээгүй бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол сайд тус тус хүчингүй болгоно. Тухайн тушаалтай холбоотой маргаан гарсан тохиолдолд иргэн, хуулийн этгээд шүүхэд нэхэмжлээс гаргаж болно.

9.10 Төрийн нарийн бичгийн даргад зөвлөх үүрэг бүхий яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нараас бүрдсэн зөвлөл байгуулан ажиллуулж болно. Зөвлөлийн ажиллах журмыг Төрийн нарийн бичгийн дарга батална.

9.11 Төрийн нарийн бичгийн даргыг түр эзгүйд албан үүргийг нь түр орлон гүйцэтгүүлэх шаардлагатай гэж үзвэл энэ тухай шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэн сайд гаргана.

## 10 дугаар зүйл. Яамны зохион байгуулалтын бүтэц

10.1 Яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцийг Засгийн газар батална.

10.2 Яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагааны стратеги, ажлын байрны тодорхойлолтыг Төрийн нарийн бичгийн дарга батална.

## 11 дүгээр зүйл. Яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн удирдлага

11.1 Яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргыг Төрийн нарийн бичгийн дарга томилж, чөлөөлнө.

11.2 Яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нь дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

11.2.1 нэгжийнхээ өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, үр дүнг Төрийн нарийн бичгийн даргын өмнө хариуцах;

11.2.2 сайд, Төрийн нарийн бичгийн даргыг мэргэшлийн зөвлөгөө мэдээллээр хангах;

11.2.3.Төрийн нарийн бичгийн даргын эрх олгосноор нэгжийнхээ ажилтантай үр дүнгийн гэрээ байгуулж, дүгнэх;

11.2.4.энэ хуулийн 9.6.1-д заасан дүрэм, заавар, журмыг нэгжийнхээ хэмжээнд мөрдүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;

11.2.5.нэгжийнхээ ажилтны үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг тогтоосон журмын дагуу үнэлж дүгнэн, саналын хамт Төрийн нарийн бичгийн даргад танилцуулж шийдвэрлүүлэх;

11.2.6.яамны хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу бусад байгууллагатай харилцах.

## **12 дугаар зүйл. Яамны ажлын зохион байгуулалт**

12.1.Яам нь чиг үүрэг, эрхэм зорилго, стратегийн зорилтоо хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөтэй ажиллана.

12.2.Яамны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө нь сайдаас яамны төсвийн ерөнхий менежертэй байгуулах үр дүнгийн гэрээний салшгүй хэсэг байна.

12.3.Яамны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөний төслийг боловсруулах, батлах, биелэлтийг нь дүгнэх журмыг хуулиар тогтооно.

12.4.Яамны хэмжээнд Төрийн нарийн бичгийн даргын хууль тогтоомжид нийцүүлж баталсан хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөнө.

12.5.Яамны хөдөлмөрийн дотоод журамд дараахь асуудлыг тусгана:

12.5.1. албан тушаалд томилох, албан тушаалаас чөлөөлөх, талах;

12.5.2.зөхиргээ, ажилтны эрх, үүрэг;

12.5.3.яамны ажлыг төлөвлөх, тайлагнах;

12.5.4.яамны зохион байгуулалтын бүтцийн нэгж, ажилтны үйл ажиллагааны үр дүнг тооцож дүгнэх, арга хэлбэр;

12.5.5.ажлын цагийн горим;

12.5.6.ажил хүлээлцэх;

12.5.7.дотоодын хяналт шалгалт хийх;

12.5.8.шагнал урамшуулал олгох;

12.5.9.сахилгын шийтгэл ногдуулах;

12.5.10.дотоод журамд тусгахаар хууль тогтоомжид заасан бусад зүйл.

12.6.Төрийн нарийн бичгийн дарга болон энэ хуулийн 11.2-т заасан албан тушаалтан яамны эрхлэх асуудлаар албан ёсны байр сууриа илэрхийлэхдээ Засгийн газар, сайдын бодлогыг баримтална.

## **13 дугаар зүйл. Ажлын нөхцөл**

13.1.Яам нь ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулан баталж, түүнд тусгасан арга хэмжээг үйл ажиллагааныхаа хэтийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

## **14 дүгээр зүйл. Яамны төсөв**

14.1.Яам нь төсөвтэй байна.

14.2.Яамны төсвийн төслийг боловсруулах, батлах, захиран зарцуулах, тайлагнах журмыг хуулиар тогтооно.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

### **Яамнаас Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, бусад байгууллагатай харилцах**

#### **15 дугаар зүйл. Сайдаас Улсын Их Хуралтай харилцахад дэмжлэг үзүүлэх**

15.1.Яам нь сайдаас Улсын Их Хуралтай харилцахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр дараахь үйл ажиллагаа явуулна:

15.1.1.Улсын Их Хурал, түүний Байнгын хороог сайдын эрхлэх асуудлын хүрээний талаархи шаардлагатай мэдээллээр хангах;

15.1.2.Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцэх бүх шатанд тайлбар, зөвлөгөө, лавлагаа өгөх;

15.1.3.Улсын Их Хурлын удирдлага, Байнгын хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар Улсын Их Хурлын гишүүнээс шаардсан мэдээллийг гаргаж өгөх;

15.1.4.сайдаас Улсын Их Хурлын чуулганд хийх мэдээллийн болон Улсын Их Хурлын гишүүнээс тавьсан асуулт, асуулгын хариултын төслийг бэлтгэх.

15.2.Хуульд өөрөөр заагаагүй бол яамнаас Улсын Их Хурлын гишүүнтэй сайдаараа





дамжуулан, Улсын Их Хурлын Тамгын газартай шууд харилцана.

15.3. Улсын Их Хурлын гишүүн нь Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай<sup>1</sup> хуулийн 7 дугаар зүйлд заасан үндсэн бүрэн эрхийнхээ хүрээнд яамтай харилцана.

### 16 дугаар зүйл. Сайдаас Ерөнхийлөгчтэй харилцахад дэмжлэг үзүүлэх

16.1. Яам нь сайдаас Ерөнхийлөгчтэй харилцахад нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр дараахь үйл ажиллагаа явуулна:

16.1.1. Ерөнхийлөгчийг сайдын эрхлэх асуудлын хүрээний талаархи шаардлагатай мэдээллээр хангах;

16.1.2. Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн холбогдох шийдвэрийн биелэлтийг хангах;

16.1.3. сайдын эрхлэх асуудлын хүрээний чиглэлээр Ерөнхийлөгчийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;

16.1.4. хууль тогтоомжид заасны дагуу Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх зарлиг, бусад бичиг баримтын төсөл боловсруулах. . . . .

16.2. Хуульд өөрөөр заагаагүй бол яамнаас Ерөнхийлөгчтэй харилцахдаа сайдаараа дамжуулан, түүний ажлын албатай шууд харилцана. Ерөнхийлөгч яамтай сайдаар, түүний ажлын алба нь энэ хуулийн 3.5-д заасан албан тушаалтнаар дамжуулан харилцана.

### 17 дугаар зүйл. Сайдаас Засгийн газартай харилцахад дэмжлэг үзүүлэх

17.1. Яамнаас Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүнтэй харилцахдаа сайдаараа дамжуулан харилцана. Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүн яамтай шууд харилцана.

17.2. Яам нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийн талаар ажлын албаар нь дамжуулан Засгийн газарт тогтоосон журмын дагуу мэдээлнэ.

### 18 дугаар зүйл. Нутгийн өөрөө удирдах байгууллагатай харилцах

18.1. Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллагатай аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн

Хурлын Тэргүүлэгчдийн даргаар дамжуулан харилцана. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь яамтай сайдаар дамжуулан харилцана.

18.2. Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллагаас тавьсан санал, хүсэлтийг хянан шийдвэрлэнэ.

### 19 дүгээр зүйл. Нутгийн захиргааны байгууллагатай харилцах

19.1. Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд нутгийн захиргааны байгууллагатай аймаг, нийслэлийн Засаг даргаар дамжуулан харилцана. Нутгийн захиргааны байгууллага нь яамтай сайдаар дамжуулан харилцана.

19.2. Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд холбогдох хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон сайдын шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байгаа байдалтай орон нутагт танилцаж, биелэлтийг хангуулна.

19.3. Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд аймаг, нийслэлийн Засаг даргаас сайдад хандаж тавьсан санал, хүсэлтийг зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.

### 20 дугаар зүйл. Яам хоорондын хамтын ажиллагаа

20.1. Яамд нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд бодлого боловсруулах, хэрэгжүүлэхдээ шаардлагатай асуудлаар хамтарч ажиллана. Хамтран ажиллах асуудлын хүрээ нь хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын үүрэг даалгавраар болон холбогдох яамдын удирдлагын түвшинд харилцан тохиролцооноор тодорхойлогдоно.

20.2. Удирдлагын түвшинд тохиролцсон асуудлаар яамд хоорондоо шууд харилцаж ажиллана.

20.3. Яамд нь бодлого боловсруулах, хэрэгжүүлэхдээ харилцан мэдээлэл солилцож, шаардлагатай асуудлаар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж ажиллана.

### 21 дүгээр зүйл. Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагтай харилцах

21.1. Яам сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, Засгийн газраас байгуулсан бусад байгууллагад хууль тогтоомж.

<sup>1</sup> Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1997 оны 4 дүгээрт нийтлэгдсэн

Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон сайдын бодлого, шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлж байгаа болон үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих, биелэлтийг нь хангуулах арга хэмжээ авч, тэдгээрт туслалцаа үзүүлнэ.

21.2. Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах агентлагтай харилцахдаа Ерөнхий сайд даалгасан бол энэ хуулийн 21.1-д заасан үүргийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга хэрэгжүүлнэ.

21.3. Агентлаг, Засгийн газраас байгуулсан бусад байгууллага нь сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлого боловсруулах удирдамжаар хангах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ өгөхөд шаардлагатай тооцоо, судалгаа, мэдээ тайлан зэрэг мэдээллийг тогтоосон журмын дагуу гаргаж өгнө.

## 22 дугаар зүйл. Бусад байгууллага, иргэдтэй харилцах

22.1. Яам нь Үндсэн хуулийн цэц, бүх шатны шүүх, прокурорын болон Улсын Их Хурлаас байгуулдаг бусад байгууллагатай, эдгээр байгууллага нь яамтай сайдаар дамжуулан харилцана.

22.2. Яам нь сайдынхаа эрхлэх асуудлын хүрээний бус агентлагтай шууд харилцана.

22.3. Яам нь гадаад улсын болон олон улсын байгууллагатай сайдын өгсөн чиглэл, удирдамж, эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлаар харилцана.

22.4. Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагатай хуульд заасан журмаар харилцана.

22.5. Яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээний тодорхой чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагад нийтлэг зорилтыг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

22.6. Яам нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон нийтлэг асуудлаар тэдгээрийн улсын чанартай холбоо, нийгэмлэг зэрэг нэгдлээр нь дамжуулан тодорхой асуудлаар шууд харилцана.

22.7. Яам нь иргэдээс сайдын эрхлэх хүрээний асуудлаар гаргасан санал, өргөдөл,

гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд\* заасан журмын дагуу хүлээ авч хянан шийдвэрлэнэ. Яам нь сайдаас иргэдийг хүлээн авч уулзах ажлыг сард 2-оос доошгүй удаа зохион байгуулна.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Бусад зүйл

#### 23 дугаар зүйл. Яамны хэвлэл

23.1. Яам нь сайдын тушаал, яамны бодлого, үйл ажиллагааны талаар нийтэд албан ёсоор мэдээлж байх зорилгоор эмхтгэл гаргаж болно.

#### 24 дүгээр зүйл. Яамны гадаад харилцаа

24.1. Яам нь өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар гадаад улсын ижил төрлийн яам, бусад байгууллага, олон улсын байгууллагатай харилцаа тогтоож хамтран ажиллана.

24.2. Төрийн нарийн бичгийн даргын гадаад улсын ижил төрлийн яам, бусад байгууллага, олон улсын байгууллагад туршлага судлах, мэргэжлийн сургалт, хурал, зөвлөлгөөнд оролцох /цаашид "албан томилолт" гэх/ асуудлыг сайд шийдвэрлэнэ.

24.3. Яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга болон ажилтны албан томилолтын асуудлыг Төрийн нарийн бичгийн дарга шийдвэрлэнэ.

24.4. Гадаад улсын болон олон улсын байгууллагаас мэргэжилтэн, зочин, төлөөлөгчүрх асуудлыг сайд шийдвэрлэнэ.

#### 25 дугаар зүйл. Яаманд хориглох зүйл

25.1. Яаманд дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

25.1.1. Жагсаал, цуглаан хийх, ажил хаялт, өлсгөлөн, суулт зарлах зэрэг улс төрийн болон шашны үйл ажиллагаа явуулах;

25.1.2. Хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд аливаа хэлбэрээр орлого олох;

25.1.3. Монгол Улсын олон улсын гэрээ, Засгийн газрын шийдвэрт зааснаас бусад тохиолдолд яамны байранд бусад байгууллагыг байрлуулах;

\* Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль-Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн



25.1.4.хууль тогтоомжоор  
ориглосон бусад үйл ажиллагаа.

## 26 дугаар зүйл. Яамны шагнал

26.1.Яам нь дараахь шагналтай байж болно:

26.1.1.яамны хүндэт дэвтэрт  
ичиж, дурсгалын гэрчилгээ олгох;

26.1.2.яамны жуух бичиг.

26.2.Яамнаас олгох шагналын нийтлэг  
загвар, дагалдах мөнгөн шагналын хэмжээг Засгийн  
газар тогтооно.

26.3.Яамны шагнал олгох, шагналын сан  
бүрдүүлэх, зарцуулах журмыг сайд тогтооно.

МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр  
сарын 15-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Нийтлэг үндэслэл

#### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Засгийн газрын  
агентлаг /цаашид "агентлаг" гэх/-ийн зохион  
байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг  
тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг  
зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл. Агентлагийн тухай хууль тогтоомж

2.1. Агентлагийн тухай хууль тогтоомж нь  
Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Засгийн газрын тухай  
<sup>2</sup>, Төрийн албаны тухай<sup>3</sup>, Яамны эрх зүйн байдлын  
тухай, Төсвийн байгууллагын удирдлага,  
санхүүжилтийн тухай<sup>4</sup>, Хөдөлмөрийн тухай<sup>5</sup> хууль,  
энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан  
хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

#### 3 дугаар зүйл. Агентлаг, түүний чиг үүрэг

3.1. Агентлаг нь Засгийн газрын үйл  
ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг  
улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий  
төрийн захиргааны байгууллага мөн.

3.2.Засгийн газар нь тохируулах болон  
хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий агентлагтай байж  
болно.

#### 4 дүгээр зүйл. Агентлагийн үйл ажиллагааны зарчим

4.1.Агентлаг нь үйл ажиллагаандаа  
Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн  
2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны  
үндсэн зарчмаас гадна төрийн үйлчилгээг жигд,  
чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод,  
мэргэшсэн байх, хууль ёсыг сахих, үйл  
ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх зарчмыг  
баримтлан ажиллана.

#### 5 дугаар зүйл. Агентлаг байгуулах

5.1.Хуульд өөрөөр заагаагүй, бол  
агентлагийг Улсын Их Хурлаас зөвшөөрсөн төрийн  
захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн  
ерөнхий бүдүүвчийн дагуу тухайн үйл ажиллагааны  
зохих хүрээ, Ерөнхий сайд, сайд /цаашид "сайд"гэх/  
-ын саналыг үндэслэн Засгийн газар байгуулна.

5.2.Сайд агентлаг байгуулах тухай саналдаа  
дараахь үндэслэлийг тусгана:

5.2.1.тухайн агентлаг нь төрөөс зайлшгүй  
хэрэгжүүлэх чиг үүрэг, үзүүлэх үйлчилгээг  
хэрэгжүүлэх үндэслэл;

5.2.2.тухайн агентлагийн үйл ажиллагаа  
Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжих;

5.2.3.агентлагийн үйл ажиллагаа төрийн  
захиргааны бусад байгууллагын чиг үүрэг,  
үйлчилгээтэй давхардахгүй байх.

5.3.Агентлаг байгуулах тухай саналд дор  
дурдсан баримт бичгийг хавсаргана:

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн

<sup>2</sup> Засгийн газрын тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1993 оны 3 дугаарт нийтлэгдсэн

<sup>3</sup> Төрийн албаны тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн

<sup>4</sup> Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 28 дугаарт  
нийтлэгдсэн

<sup>5</sup> Хөдөлмөрийн тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 25 дугаарт нийтлэгдсэн

5.3.1. үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, бүтцийн хөтөлбөрийн төсөл;

5.3.2. жилийн төсөв, санхүүжилтийн эх үүсвэрийн тухай танилцуулга, холбогдох тооцоо, судалгаа.

5.4. Засгийн газар нь агентлаг байгуулах зайлшгүй шаардлагатай эсэх талаар дүгнэлт гаргуулахаар ажлын хэсэг байгуулж болно.

5.5. Засгийн газар тухайн агентлагийг байгуулах шаардлагатай гэж үзвэл төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

## **6 дугаар зүйл. Агентлагийг өөрчлөн байгуулах, татан буулгах**

6.1. Агентлагийг нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулна.

6.2. Агентлагийг дараахь үндэслэлээр татан буулгана:

6.2.1. тухайн агентлагаас хэрэгжүүлж байсан чиг үүрэг, үйлчилгээ нь төрийн чиг үүрэг, үзүүлэх үйлчилгээнд хамаарахгүй болсон;

6.2.2. хуульд заасан бусад үндэслэл.

6.3. Хуульд өөрөөр заагаагүй бол агентлагийг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Улсын Их Хурлаас зөвшөөрсөн төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийн дагуу Засгийн газар шийдвэрлэнэ.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **Агентлагийн эрхлэх асуудал, удирдлага, зохион байгуулалтын бүтэц**

#### **7 дугаар зүйл. Агентлагийн нийтлэг эрхлэх асуудал**

7.1. Агентлаг нь дараахь нийтлэг асуудал эрхэлнэ:

7.1.1. хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон сайдын шийдвэрийг биелүүлэх ажлыг эрхэлсэн хүрээ, салбарын хэмжээнд зохион байгуулж, биелэлтийг хангах;

7.1.2. холбогдох хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон

сайдын шийдвэрийг сурталчлах, тэдгээрийг хэрэглэж байгаа практикийг судалж, боловсронгй болгох санал боловсруулж сайдад танилцуулах.

7.1.3. төсвийн хүрээний мэдэгдлийн төсөвд өгөх саналыг үндэслэл, тооцоотой боловсруулах;

7.1.4. агентлагийн хэтийн болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, үндсэн чиглэл, төсвийн төслийг хуульд заасан нөхцөл, үндэслэлээр хугацаанд нь боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчид оруулах;

7.1.5. хуульд өөрөөр заагаагүй бол аймг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгж, Засаг даргын дэргэдэх холбогдох байгууллагад эрхэлж буй ажлын чиглэлээр мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж;

7.1.6. салбарынхаа хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

7.1.7. хүний эрх, эрх чөлөөг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх арга хэмжээ авах;

7.1.8. Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг тэдгээрт нийцүүлэх санал боловсруулж сайдад танилцуулах;

7.1.9. хуулиар эрх олгосон бол нийтээ дагаж мөрдүүлэх заавар, дүрэм, журам, норм, нормативыг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах, тэдгээрийн биелэлтэд хяналт тавих;

7.1.10. хууль тогтоомжид заасан бусад нийтлэг эрхлэх асуудал.

7.2. Агентлагийн эрхлэх тодорхой асуудлыг хууль тогтоомж, хуулиар эрх олгосон бол Засгийн газрын шийдвэрээр тогтооно.

#### **8 дугаар зүйл. Агентлагийн удирдлага**

8.1. Агентлагийг Засгийн газрын тухай хуулийн 18<sup>1</sup> дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу томилогдсон дарга тэргүүлнэ.

8.2. Агентлагийн дарга агентлагийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, түүний үр дүнг сайдын өмнө хариуцан тайлагнана.

8.3. Агентлагийн дарга нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.3.1. энэ хуулийн 7.1.1-д заасан хууль тогтоомж, зарлиг, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, явц, биелэлтэд хяналт тавих;

8.3.2. агентлагийг өдөр тутмын удирдлагаар хангах, хуулиар эрх олгосон бол нийтээр дагаж мөрдүүлэх заавар, дүрэм, журиыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Засгийн газраас баталсан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, мөрдүүлэх;

8.3.3. агентлагийн төсвийн ерөнхий менежерийн хувьд төсвийн ерөнхийлөн захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулах, биелэлтийг хангах;

8.3.4. батлагдсан төсөв, сайдын баталсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт багтаан агентлагийн орон тоо, цалингийн санг тогтоох;

8.3.5. хууль тогтоомжид заасны дагуу албан тушаалд томилох, чөлөөлөх, албан тушаалаас бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, шагнаж урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, төрийн албанаас чөлөөлөх, түр чөлөөлөх, халах;

8.3.6. эрхэлсэн асуудлаараа сайдад мэргэшлийн зөвлөгөө өгч, холбогдох мэдээллээр хангах;

8.3.7. агентлагийн төсвийг тогтоосон журмын дагуу захиран зарцуулах;

8.3.8. тогтоосон журмын дагуу агентлагийн нэр дээр банкинд харилцах данс нээх;

8.3.9. агентлагийг төлөөлж бусад байгууллагатай харилцах;

8.3.10. салбарын мэдээллийн тогтолцоо бүрдүүлэх, төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардагдах тооцоо, судалгаа, мэдээ, материалыг хуульд харшлаагүй бол холбогдох байгууллага, аж ахуйн нэгжээс гаргуулан авах;

8.3.11. хуульд заасны дагуу олгосон болон сайдаас шилжүүлсэн бусад бүрэн эрх.

8.4. Агентлагийн дарга энэ хууль болон холбогдох бусад хуулиар олгосон бүрэн эрхэд хамаарах асуудлаар тушаал гаргана.

8.5. Агентлагийн дарга нь Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдана.

8.6. Агентлагийг гадаад, дотоодод агентлагийн дарга төлөөлнө. Агентлагийн даргын даалгаснаар болон хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга агентлагийг төлөөлж болно.

## 9 дүгээр зүйл. Агентлагийн зохион байгуулалтын бүтэц

9.1. Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлгөөр болон зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг Монгол Улсын сайд батална.

9.2. Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагааны стратеги, ажлын байрны тодорхойлолтыг агентлагийн дарга батална.

9.3. Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нэгжийнхээ өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, үр дүнг агентлагийн даргын өмнө хариуцана.

## 10 дугаар зүйл. Агентлагийн ажлын зохион байгуулалт

10.1. Агентлаг нь үнэг үүрэг, эрхэм зорилго, стратегийн зорилтоо хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөтэй ажиллана.

10.2. Агентлагийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө нь төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулах ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээний бүрэлдэхүүн хэсэг байна.

10.3. Агентлагийн хэмжээнд агентлагийн даргын хууль тогтоомжид нийцүүлэн баталсан хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөнө.

10.4. Хөдөлмөрийн дотоод журамд дараахь үндсэн зүйлийг тусгана:

10.4.1. агентлагийн ажлыг төлөөлөх, тайлагнах журам;

10.4.2. албан тушаалд томилох, албан тушаалаас чөлөөлөх, халах;

10.4.3. захиргаа, албан хаагчийн эрх, үүрэг;

10.4.4. зохион байгуулалтын нэгж, ажилтны үйл ажиллагааны үр дүнг тооцож, дүгнэх арга хэлбэр;

10.4.5. дотоодын хяналт, шалгалт хийх, шагнаж урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах;

10.4.6. дотоод журамд тусгахаар хууль тогтоомжид заасан бусад зүйл.

10.5. Хөдөлмөрийн дотоод журмыг ажилтан бүрт танилцуулсан байна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

**Агентлаг нь бусад байгууллага, албан тушаалтантай харилцах**

### 11 дүгээр зүйл. Агентлаг нь бусад байгууллага, албан тушаалтантай харилцах

11.1. Агентлаг нь эрхэлсэн асуудлаараа Монгол Улсын сайд, Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын нэгжийн дарга, ажилтантай шууд харилцана.

11.2. Агентлаг нь хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, шүүх, прокурор болон Улсын Их Хурлаас байгуулдаг бусад байгууллага, тэдгээрийн ажлын алба, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнтэй сайдаар дамжуулан харилцах ба эдгээр байгууллага, албан тушаалтан нь агентлагтай мөн сайдаар дамжуулан харилцана.

11.3. Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Засгийн газартай Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар дамжуулан харилцана.

11.4. Агентлаг нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, бусад яам, агентлагтай хуульд өөрөөр заагаагүй бол шууд харилцана.

11.5. Агентлаг нь эрхлэх асуудлаараа нутгийн өөрөө удирдах байгууллагатай аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргаар дамжуулан харилцана.

11.6. Агентлаг нь эрхлэх асуудлаараа нутгийн захиргааны байгууллагатай аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргаар дамжуулан харилцана.

11.7. Агентлаг нь эрхлэх асуудлаараа энэ зүйлд зааснаас бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэнтэй шууд харилцана.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

**Агентлагийн санхүүжилт, эд хөрөнгө**

### 12 дугаар зүйл. Агентлагийн санхүүжилт

12.1. Агентлаг нь улсын төсвөөс буюу үйл

ажиллагааныхаа орлогоос санхүүжиж болно.

12.2. Улсын төсвөөс санхүүждэг агентлагийн төсвийн төслийг боловсруулах, батлах, захиран зарцуулах, тайлагнах журмыг хуулиар тогтооно.

12.3. Үйл ажиллагааныхаа орлогоос санхүүждэг агентлагийн тухайн жилийн төсвийг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, эрхэлсэн асуудлын хүрээнд нь тухайн агентлаг хамаарч байгаа Засгийн газрын гишүүн хамтран батална.

12.4. Үйл ажиллагааныхаа орлогоос санхүүждэг агентлагийн тухайн жилийн орлогоос батлагдсан зардлыг нөхөж, төсөвт төлөх төлбөрийн тооцоо хийсний дараа үлдэх орлогын зохих хэсгийг тухайн агентлагт хөрөнгө оруулалт хийх, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулахаар үлдээж, бусдыг нь улсын төсөвт оруулна.

12.5. Тухайн агентлагийн мэдэлд үлдээх орлогын хувь хэмжээг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, эрхэлсэн асуудлын хүрээнд нь тухайн агентлаг хамаарч байгаа Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.

### 13 дугаар зүйл. Агентлагийн эд хөрөнгө

13.1. Агентлаг нь төрөөс өөрт нь олгосон эд хөрөнгөтэй байна.

13.2. Агентлаг нь өөрт нь олгосон эд хөрөнгө болон хуульд заасны дагуу олсон орлогоороо бий болгосон эд хөрөнгийг хуульд заасан журмын дагуу эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулна.

## ТАВДУГААР БҮЛЭГ

**Бусад зүйл**

### 14 дүгээр зүйл. Агентлагийн хэвлэл

14.1. Агентлагийн даргын тушаал, үйл ажиллагааныхаа талаар албан ёсоор нийтэд мэдээлэх зорилгоор агентлаг нь эмхтгэл гаргаж болно.

14.2. Агентлагийн удирдлага, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга эрхлэх асуудлаараа албан ёсны мэдээлэл хийхдээ Засгийн газар, Монгол Улсын сайдын бодлогыг баримтална.

### 15 дугаар зүйл. Агентлагийн гадаад харилцаа



15.1.Агентлаг нь өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар гадаад улсын ижил төрлийн байгууллага, олон улсын болон бусад байгууллагатай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын сайдын тогтоосон журмыг үндэслэн гэрээ, хэлэлцээр байгуулж хамтран ажиллана.

15.2.Агентлагийн даргыг гадаад улсын ижил төрлийн байгууллага, олон улсын болон бусад байгууллагад туршлага судлах, мэргэжлийн сургалтад явах, хурал, зөвлөлгөөнд оролцох / цаашид албан томилолт гэх-ыг Монгол Улсын сайд шийдвэрлэнэ.

15.3.Бүтцийн нэгжийн дарга, ажилтны албан томилолтоор ажиллах асуудлыг агентлагийн дарга шийдвэрлэнэ.

15.4.Агентлагаас гадаад улсын ижил төрлийн байгууллага, олон улсын байгууллагаас мэргэжилтэн, зочид, төлөөлөгч урих асуудлыг Монгол Улсын сайд шийдвэрлэнэ.

**16 дугаар зүйл.Агентлагийн тамга, тэмдэг, бэлгэдэл**

16.1.Агентлаг тогтоосон журмаар хийсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

16.2.Энэ хуулийн 16.1-д заасан тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэх журмыг Засгийн газар тогтооно.

16.3.Агентлаг нь эрхэлсэн ажлын онцлог, түүхэн уламжлалыг илэрхийлсэн бэлгэдэлтэй байж болно.

16.4.Хуульд өөрөөр заагаагүй бол агентлагийн бэлгэдлийн загвар, тодорхойлолт, хэрэглэх журмыг агентлагийн дарга тогтооно.

**17 дугаар зүйл. Агентлагийн шагнал**

17.1.Агентлаг нь дараахь шагналтай байж болно:

17.1.1.агентлагийн хүндэт дэвтэрт бичиж, дурсгалын гэрчилгээ олгох;  
17.1.2.агентлагийн хүндэт өргөмжлөл.

17.2.Энэ хуулийн 17.1-д заасан шагнал олгох чийтлэг журмыг Засгийн газар тогтоож, шагналын тодорхойлолт, загварыг тухайн агентлагийн дарга батална.

**18 дугаар зүйл. Агентлагийн үйл ажиллагаанд хориглох зүйл**

18.1.Агентлагт дараахь үйл ажиллагааг явуулахыг хориглоно:

18.1.1. жагсаал, цуглаан хийх, ажил хаялт, өлсгөлөн, суулт зарлах зэрэг улс төрийн болон шашны үйл ажиллагааг явуулах;

18.1.2.хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд аливаа хэлбэрээр орлого олох үйл ажиллагааг явуулах;

18.1.3.Монгол Улсын олон улсын гэрээ, Засгийн газрын шийдвэрт зааснаас бусад тохиолдолд үндсэн үйл ажиллагаатай нь холбоо бүхий үйлчилгээ үзүүлдэг байгууллага, аж ахуйн нэгжээс бусад аж ахуйн нэгж, байгууллагыг агентлагийн байранд байрлуулах;

18.1.4. хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрээр хориглосон бусад үйл ажиллагааг.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2004 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Засгийн газрын тухай хуульд дор дурдсан агуулгатай 18<sup>1</sup> дүгээр зүйл нэмсүгэй:

"18<sup>1</sup> дүгээр зүйл. Дэд сайдын бүрэн эрх

1.Дэд сайд сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/сайдад улс төрийн бодлогын асуудлаар зөвлөх, мэдээллээр хангах;

2/сайдын нэрийн өмнөөс холбогдох агентлаг, бусад байгууллагатай өдөр тутам харилцах, тэдгээрийн үйл ажиллагааг нэгтгэн зохицуулах;

3/хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн шуурхай зохицуулалтыг хангуулах;





4/сайдын даалгаснаар Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргатай харилцах;

5/Улсын Их Хурал, түүний Байнгын хороо, Ерөнхийлөгч, Засгийн газар, Ерөнхий сайдаас байгуулах хороо, комисс, зөвлөл, ажлын хэсэгт сайдын түр эзгүйд түүний даалгаснаар сайдыг төлөөлөх;

6/хуульд заасан бусад бүрэн эрх.

2.Сайдын түр эзгүйд түүнийг орлож байх хугацаанд гаргасан шийдвэрээ сайдад танилцуулах бөгөөд уг шийдвэрийнхээ хууль зүйн үр дагаврыг өөрөө хариуцна.

3.Дэд сайдын бүрэн эрхийн хугацаа нь Засгийн газрын бүрэн эрхийн хугацаатай адил байна.

4.Дэд сайдын бүрэн эрхийн хугацаа нь түүнийг Засгийн газар томилсноор эхэлж, тухайн дэд сайдыг шинээр томилсноор дуусгавар болно.

5.Дэд сайд хуульд заасан үндэслэлээр албан тушаалаас огцорсон, чөлөөлөгдсөн, түүнчлэн нас нөгчсөн тохиолдолд түүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болно.

6.Дэд сайдыг орон гарсан тохиолдолд Засгийн газар 30 хоногийн дотор түүнийг нөхөн томилно. Нөхөн томилогдсон дэд сайдын бүрэн эрхийн хугацаа тухайн Засгийн газрын бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

7.Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээр огцорсон, Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон нь албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж ирсэн дэд сайдыг уг албан тушаалд дахин томилоход саад болохгүй.

8.Сайд хуульд заасан үндэслэлээр албан тушаалаас огцорсон, чөлөөлөгдсөн, түүнчлэн нас нөгчсөн нь албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж ирсэн дэд сайдыг албан тушаалаас нь чөлөөлөх үндэслэл болохгүй.

9.Биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд албан тушаалаас чөлөөлж өгөх тухай хүсэлтээ дэд сайд Ерөнхий сайдад өргөн мэдүүлж болно.

10.Дэд сайд бодлогын асуудлаар сайдтай санал зөрснөөс бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, түүнчлэн хуульд заасан бусад үндэслэл байна гэж үзвэл албан тушаалаасаа огцрох тухай хүсэлтээ Ерөнхий сайдад өргөн мэдүүлж болно. Харин энэ талаар эцсийн шийдвэр гаргал үүрэгт ажлаа гүйцэтгэж, хариуцлагыг нь хүлээнэ."

**2 дугаар зүйл.** Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Засгийн газрын гишүүд удирдлагын түвшинд тохиролцсон асуудлаар хамтарсан тушаал гаргаж болно." гэсэн агуулгатай 3 дахь өгүүлбэр нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"3.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн болон тодорхой хүрээний ажил эрхэлнэ. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний эрхлэх үндсэн хүрээний ажлыг энэ хуулиар, тодорхой ажлыг бусад хуулиар зохицуулна."

**4 дүгээр зүйл.** Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 1 дэх өгүүлбэрийн "мэргэшлийн үндсэн дээр" гэснийг, 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 3 дахь заалтын "шүүхийн байгууллагын зохион байгуулалт, санхүү, материал техникийн хангамж, үйлчилгээ" гэснийг тус тус хассугай.

**5 дугаар зүйл.** Засгийн газрын тухай хуулийн зүйлийн дугаарыг "18" гэснийг "18", "18" гэснийг "18" гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

### СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Соёлын өвийг хамгаалах тухай хуульд дараахь зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

"22' дугаар зүйл.Соёлын өвийн хяналт

1/22' дугаар зүйл:



22'1. Соёлын өвийн хяналтыг мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх байгууллага, улсын байцаагч, бүх шатны Засаг дарга хэрэгжүүлнэ.

22'2. Мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх байгууллага нь соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж, дүрэм, журам, түүнтэй холбогдсон норм, стандартын хэрэгжилтэд хяналт тавина.

22'3. Энэ хуулийн 3.1.1, 3.1.2, 3.1.8 -д дурдсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалтад байгаль орчны байцаагч хяналт тавина."

2/8 дугаар зүйлийн 11 дэх хэсэг:

"8.11. Сум, дүүргийн Засаг дарга 8.9-д заасан болон тухайн нутаг дэвсгэрт зөвшөөрөлгүй малтлага, хайгуул хийж байгаа мэдээллийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 7 хоногийн дотор мэдээлнэ."

3/17 дугаар зүйлийн 15 дахь хэсэг:

"17.15. Сум, дүүргийн Засаг дарга түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах үүргийг гэрээний үндсэн дээр иргөн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно."

4/23 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"23.2. Энэ хуулийн 8.11, 20.1-ийг зөрчсөн зөрчлийг шүүгч, 11.4, 12.2, 12.3, 17.7, 17.10, 17.13-г зөрчсөн зөрчлийг байгаль орчны улсын байцаагч, 8.1, 8.9, 9.4, 9.6, 11.4, 12.3, 13.2, 13.4, 14.2, 15.2, 16.3, 17.7, 17.10, 17.13, 20.1, 21.1, 23.1.1, 23.1.3-г зөрчсөн зөрчлийг сум, дүүргийн Засаг дарга, соёлын хяналтын улсын байцаагч, 23.1.7-д заасан зөрчлийг соёлын хяналтын улсын байцаагч тус тус харьяалан шийдвэрлэнэ."

5/23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

"23.1.7. энэ хуулийн 8.6, 9.7-г зөрчсөн албан тушаалтныг 30000-60000, байгууллага, аж ахуйн нэгжийг 100000-250000 төгрөгөөр торгох."

6/23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт:

"23.1.8. шүүгч энэ хуулийн 8.11, 20.1-ийг зөрчсөн албан тушаалтныг 30000-60000, хуулийн этгээдийг 100000-250000 төгрөгөөр торгох;"

**2 дугаар зүйл.** Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 3.1.7 -гийн "дурсгалт" гэсний дараа "цогцолбор", 4.1-ийн "арга барил" гэсний дараа "дэг сургууль", 5.2-ын "холбогдох" гэсний дараа "музей", 6.1.2-ын "аймаг, нийслэлийн" гэсний өмнө "сум", 15.2.2-ын "зүйлийг" гэсний дараа "даатгалд хамруулан", 17.1-ийн "нийслэл" гэсний дараа "баг", 17.6-гийн "барилга," гэсний дараа "археологи, палеонтологи болон", "хамгаалалтын" гэсний дараа "болон түүх, соёлын дурсгал цогцолбор газрын", 23.1.1-ийн "17.13" гэсний дараа ", 21.1", 23.1.2-ын "9.6" гэсний дараа ", 10.3", 23.1.3-ийн "зөвж тээвэрлэх" гэсний дараа ", тооллого хийх", 23.1.5-ийн "ирээгүй" гэсний дараа "иргэнийг 20000-50000, албан тушаалтныг 30000-60000," гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт: . . . . .

"3.1.8.эртний хүн, амьтан, бичил биетэн, ургамлын чулуужсан олдвор, ул мөр, тэдгээрийг агуулсан олдворт газар;"

2/7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"7.1.Бүртгэл-мэдээллийн сан нь соёлын өвийн тодорхойлолт, судалгаа шинжилгээний ажлын товч тайлан, гэрэл зураг, слайд, дуу болон дүрс бичлэгтэй хальс ба цахим зэрэгцэг, сэргээн засварлах ажлын товч тайлан зэргээс бүрдэнэ."

3/11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"11.3.Түүх, соёлын дурсгалт зүйлийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрлийг мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно. Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

4/11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:

"11.6.Түүх, соёлын дурсгалт зүйлийн судалгаа шинжилгээний ажлын дэлгэрэнгүй тайланг 2 хувь үйлдэж, шинжлэх ухаан, технологийн мэдээллийн сан болон маллага явуулсан байгууллагад тус тус хадгална. Тайлан бүрэн эхээрээ хэвлэлд нийтлэгдээгүй тохиолдолд түүнийг ашиглах асуудлыг Зохиогчийн эрхийн тухай хууль<sup>1</sup>-ийн дагуу шийдвэрлэнэ."

5/13 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"13.3.Түүх, соёлын олдворыг цаашид судлах шаардлагатай бол судалгааг дуусгах, олдворын зэрэглэлийг тогтоолгох, холбогдох байгууллагад шилжүүлэх талаар зөвшөөрөл олгосон байгууллагатай гэрээ хийж зохицуулна."

6/20 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"20.1.Төрийн өмчлөлд байгаа түүх, соёлын хосгүй үнэт болон үнэт дурсгалт зүйлийг гагцхүү судалж шинжлэх, сурталчлах, сэргээн засварлах зорилгоор түүний хадгалалт, хамгаалалтын найдвартай нөхцөлийг бүрдүүлсний үндсэн дээр соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв

байгууллагын зөвшөөрлөөр 2 жилээс дээшгүй хугацаагаар улсын хилээр нэвтрүүлж болно. Шаардлагатай бол хугацааг сунгаж болно."

7/23 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"23.1.Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй бол шүүгч, соёлын болон байгаль орчны хяналтын улсын байцаагч, сум, дүүргийн Засаг дарга гэм буруутай этгээдэд дараахь шийтгэл ногдуулна:"

**4 дүгээр зүйл.** Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 3.1, 20.3-аас "аль нэг хэсгийг", 3.1.1-ээс "хөрсөн доорх шороон булш, нууцлагдсан", "хадны агуй, хөмөг дэх", "бүх төрөл, хэлбэрийн", 10.2-оос "бүртгэл-мэдээллийн сан", "зэрэг газарт", 13.4 -өөс "нарийвчилсан" гэсэн үгийг тус тус хассугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

### ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нэмсүгэй.

"12.1.4. улсын чанартай музей" гэсэн заалт

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

### АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 20 дахь хэсэг нэмсүгэй:

"20. Хараагүй, дүлий болох тулах эрхтний гэмтлийн улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан тахир дутуу хүн ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан

татварыг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажиллагсад тахир дутуу хүний эзэлж байгаа хувиар хөнгөлнө."

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

### ХҮН АМЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хүн амын орлогын албан татварын хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 15 дахь заалт нэмсүгэй:

гэмтлийн улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан тахир дутуу хүний орлого."

"15/хараагүй, дүлий болон тулах эрхтний

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

### НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улс, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан зээлийн /1907-МОН/ гэрээний дагуу хэрэгжиж байгаа "Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн хоёрдугаар үе шатны төсөл" -ийн хүрээнд зээлийн хөрөнгөөр гадаад, дотоодоос нийлүүлэгдэх машин механизм, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, материал,

гүйцэтгэх барилгын ажил, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

### ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улс, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан зээлийн /1907-МОН/ гэрээний дагуу хэрэгжиж байгаа "Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн хоёрдугаар үе шатны төсөл" -ийн хүрээнд зээлийн хөрөнгөөр гадаадаас нийлүүлэгдэх машин механизм, сэлбэг

хэрэгсэл, тоног төхөөрөмж, материалыг гаалийн албан татвараас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

### Хуулийн болон Улсын Их Хурлын тогтоолын төслүүд буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3.4-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулиар агентлагийн тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг хэвээр үлдээх нь зүйтэй гэж үзсэн тул Засгийн газраас өргөн мэдүүлсэн Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зохиогчийн эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Патентийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дайчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах

тухай, Авто тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шударга бус ерсөлдөөнийг хориглох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай", "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай", "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай", "Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2004 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

**Сулеймен Демирелийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай**

Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Бүгд Найрамдах Турк Улсын Ерөнхийлөгч асан Сулеймен Демирелийг "Алтан гадас" одонгоор шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**
**Н. БАГАБАНДИ**
**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2004 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар хот

**Мустафа Буминьг "Алтан гадас" одонгоор шагнах тухай**

Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Бүгд Найрамдах Турк Улсын Үндсэн хуулийн Шүүхийн дарга Мустафа Буминьг "Алтан гадас" одонгоор шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**
**Н. БАГАБАНДИ**
**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2004 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 52

Улаанбаатар хот

**Халил Акынжыг "Найрамдал" медалиар шагнах тухай**

Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Бүгд Найрамдах Турк Улсын Гадаад хэргийн яамны Төв Ази, Кавказ, Монголын асуудал эрхэлсэн Ерөнхий газрын захирал Халил Акынжыг "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**
**Н. БАГАБАНДИ**
**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2004 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 54

Улаанбаатар хот

**Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь: сум дундын 3 дугаар шүүхийн шүүгчийн, Сүхбаатарын Ганчимэгийг Дорнод аймаг дахь Хэрлэн сумын шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

Өөр ажилд, албан тушаалд томилогдох болсонтой холбогдуулан Бадарчийн Түмэнбаярыг Дорнод аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Дагвадоржийн Буянжаргалыг Сэлэнгэ аймаг дахь

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**
**Н. БАГАБАНДИ**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 3 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 66

Улаанбаатар хот

### Дүрэм батлах тухай

нь: Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ

дугаар сарын 28-ны өдрийн 206 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

1. "Аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дүрэм"-ийг хавсралт ёсоор баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**
**Н.ЭНХБАЯР**

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Цэрэг-иргэний хамгаалалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1999 оны 12

**БАТЛАН ХАМГААЛАХЫН  
САЙД** **Ж.ГҮРРАГЧАА**
*Засгийн газрын 2004 оны 66 дугаар тогтоолын хавсралт*

### АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ЦЭРГИЙН ШТАБЫН ДҮРЭМ

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штаб (цаашид "штаб" гэнэ) нь батлан хамгаалах чиглэлээр гарсан хууль тогтоомжийн биелэлтийг орон нутагт хангах ажлыг тайван болон онцгой нөхцөлийн үед зохион байгуулах, хэрэгжүүлэх, энэ чиглэлээр нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд мэргэшил, арга зүйн удирдлага, туслалцаа үзүүлэх, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2. Штаб нь өөрийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Засаг даргын захирамжийг мөрдлөг болгон ажиллана.

3. Штабын үйл ажиллагаа нь дараахь үндсэн зорилтыг хэрэгжүүлэхэд оршино:

3.1. батлан хамгаалах талаархи бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

3.2. хуульд заагдсан удирдлага, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3.3. цэрэг-техникийн тоо бүртгэл хөтлөх;

3.4. цэрэг халалт, татлага, дүйцүүлэх албаны үйл ажиллагааг зохион байгуулах;

3.5. цэргийн бэлтгэл үүрэгтний дайчилгааны болон дайчилгаатай сургуулийн бэлтгэлийг хангах;

3.6. нутаг дэвсгэртээ байрлаж байгаа зэвсэгт хүчний цэргийн анги, байгууллагатай хамтран ажиллах;

3.7. үй олноор хөнөөх зэвсэг болон хөнөөх хэрэгсэл, цэргийн зориулалттай химийн хорт бодисын хөнөөл, хордуулалт, тэдгээрийг ашиглан үйлдэгдэж болзошгүй алан хядах ажиллагаанаас сэргийлэх, иргэдийг хамгаалах, аврах, тэмцэх, хор уршгийг арилгах арга ажиллагаанд бүх нийтийг сургаж бэлтгэх, энэхүү арга ажиллагааг удирдан зохион байгуулах;

3.8. дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг орон нутагт зохион байгуулах.

4. Штаб нь зохих журмын дагуу хийгдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Штабын удирдлага, зохион байгуулалт

5. Штаб нь аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын шууд удирдлагын дор үйл ажиллагаагаа явуулна.

6. Штаб нь батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засаг даргаас захиргааны удирдлагаар, цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллагаас мэргэжлийн удирдлагаар хангагдана.

7. Хоёроос доошгүй нэр дэвшигчийг оруулан аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр штабын даргыг Батлан хамгаалахын сайд, бусад ажилтныг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргатай зөвшилцсөний үндсэн дээр Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга томилж, чөлөөлнө.

Штабын дарга, ажилтныг томилж, чөлөөлөх асуудлыг ажлын 7 хоногийн дотор шийдвэрлэнэ.

8. Штабын дарга нь дотоод ажлын төлөвлөлт, зохион байгуулалттай холбогдсон асуудлаар шийдвэр гаргаж, штабын ажилтнуудыг мэргэжлийн болон захиргааны удирдлагаар хангана.

Гурав. Штабын эрх, үүрэг

9. Штаб дор дурдсан эрхтэй байна:

9.1. хуульд заасан удирдлага, төлөвлөлтийн баримт бичгийн дагуу хүн, техникийг сум, дүүргээр хуваарилан оногдуулан данслах, тухайн сум, дүүрэг (хороо)-ийн Засаг даргаар биелэлтийг гаргуулан авах;

9.2. сум, дүүргийн дайчилгааны төлөвлөгөө, үй олноор хөнөөх зэвсэг болон хөнөөх хэрэгслийн хөнөөл, тэдгээрийг ашиглан үйлдэгдэж болзошгүй алан хядах ажиллагаанаас иргэдийг хамгаалах удирдлага, төлөвлөлтийн баримт бичгийг хянах, дүгнэлт гаргах, баталгаажуулахад дэмжлэг үзүүлэх;

9.3. холбогдох аж ахуйн нэгж, байгууллагаас шаардлагатай тайлан мэдээг гаргуулан авах;

9.4. тухайн нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагад өмчийн харьяалал харгалзахгүйгээр батлан хамгаалах асуудалтай холбогдсон хууль тогтоомжийг биелүүлэх талаар үүрэг, чиглэл өгч, биелэлтийг хангуулах;

9.5. хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд цэргийн жинхэнэ алба хаагчийн чөлөө, томилолтын хугацааг 7 хүртэл хоногоор сунгах;

9.6. орон нутагт батлан хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд идэвх зүтгэлтэй оролцсон аж ахуйн нэгж, байгууллага, цэргийн үүрэгтэн, иргэдийг шагнаж, урамшуулахаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад тодорхойлох;

9.7. хууль тогтоомжид заасан бусад эрх.

10. Штаб нь дор дурдсан үүрэгтэй байна:

10.1. салбарын талаархи бодлого, хууль тогтоомж, үйл ажиллагааг бүх нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг төлөвлөгөөтэйгээр зохион байгуулах;

10.2. хууль тогтоомжид заасан удирдлага, төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулан Засаг даргатайгаа зөвшилцсөний үндсэн дээр эрх бүхий байгууллагаар батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих;

10.3. эрх бүхий байгууллагын шийдвэр, Засаг даргын захирамжийн дагуу иргэдийг жил бүр цэргийн жинхэнэ албанд татах, халах, цэрэг-техникийн шинэчилсэн бүртгэл явуулах ажлыг зохион байгуулах, дайчилгааны даалгаврыг хангах бүх талын арга хэмжээ авах;

10.4. үй олноор хөнөөх зэвсэг болон хөнөөх хэрэгслийн хөнөөл, тэдгээрийг ашиглан үйлдэгдэж болзошгүй алан хядах ажиллагаанаас иргэдийг хамгаалах арга хэмжээг орон нутагт төлөвлөн зохион байгуулж, хяналт тавих оперативын бэлтгэлийн явц, төлөвлөлт, биелэлтэд дүгнэлт хийж боловсронгуй болгох, тэдгээрээс сэргийлэх, тэмцэх, хамгаалах, аврах, хор уршгийг



арилгах үйл ажиллагааг удирдах, мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх;

10.5. орон нутгийн хамгаалалтын удирдлага, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;

10.6. сум, дүүрэг, аж ахуйн нэгж, байгууллагаас цэргийн болон үй олноор хөнөөх зэвсэг, хөнөөх хэрэгслийн хөнөөл, тэдгээрийг ашиглан үйлдэгдэж болзошгүй алан хядах ажиллагаанаас иргэдийг хамгаалах сургалт, дадлагад оролцох хүн, техникийг тодорхойлох, үүнтэй холбогдсон төлөвлөгөө хийхэд туслэх, зарлах, мэдээлэх;

10.7. улсын хил хамгаалалтад туслэх хүчний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

10.8. цэргийн сургуульд суралцах, анги, салбарт гэрээгээр алба хаах хүсэлтээ илэрхийлсэн иргэдийг судлах, үзлэг, шалгаруулалтад оруулах;

10.9. эрхэлсэн ажлын чиглэлээр батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн удирдлагын байгууллага, Засаг даргаас өгсөн үүргийг биелүүлэх ажлыг зохион байгуулах, Засаг даргад мэргэжлийн зөвлөлгөө өгөх, үйл ажиллагаанд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх;

10.10. Батлан хамгаалахын сайдын тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;

10.11. дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг орон нутагт сургаж бэлтгэх, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдыг сургах, алба хаалгах, тэдэнтэй холбогдсон асуудлыг зохих байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

10.12. цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр дүйцүүлэн хаагчдын бүртгэлийг хөтлөн төлбөр төлүүлэх ажлыг зохион байгуулах;

10.13. цэргийн бэлтгэл үүрэгтэнг давтан сургах, цэргийн дүйцүүлэх албатай холбогдсон зардлын нэгдсэн тооцоог гаргаж, орон нутгийн төсөвт тусуулахаар аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргад уламжлах;

10.14. амралт, чөлөөгөөр болон томилолтоор орон нутагт яваа цэргийн жинхэнэ албан хаагчийг бүртгэн, чөлөөний хуудас, томилолтод тэмдэглэл хийх;

10.15. тухайн аймаг болон нийслэл, дүүргийн нутаг дэвсгэрт байгаа цэргийн үүрэгтний шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг барагдуулах;

10.16. гамшгийн аюулын үед зэвсэгт хүчнээс тусламж үзүүлэхээр томилогдсон бүрэлдэхүүний орон нутгийн мэргэжлийн байгууллагатай харилцах ажиллагааг зохион байгуулах;

10.17. аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөөтэй холбогдолтой баримт бичгийг боловсруулах, тэдгээрийн нууцлалт, хадгалалт, хамгаалалтыг зохион байгуулахад мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;

10.18. цэргийн штабын ажлын мэдээ, тайланг тогтоосон журмаар гарган батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллагад хүргүүлэх, илтгэх.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 329612  
Индекс 14003

☎ 329487

Хэвлэлийн хуудас 2.5